



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 4/36

Улаанбаатар хот

Уралдаан тэмцээний ахлагчаар томилон ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Индонези улсын Жакарта хотноо 2018 оны 08 дугаар сарын 18-аас 09 дүгээр сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулагдах Азийн 18 дахь удаагийн спортын наадамд монголын гимнастикийн баг тамирчдын ахлагчаар тус хорооны Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга Алтангэрэлийн Болдмааг оролцуулсугай.

2. Азийн наадамд оролцоход шаардагдах төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээнд оролцоход шаардагдах зочид буудал, онгоцны тийзийн зардал болох нийт 4.884.500 /Дөрвөн сая найман зуун наян дөрвөн мянга таван зуун/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамирын уралдаан, тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.

4. Дээрх үйл ажиллагаанд томилогдон ажилласан талаарх тайланг ажлыг 7 хоногт багтаан тайлагнаж, судалж мэдсэн туршлагаа ажил үүрэгтээ нэвтрүүлж ажиллахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын
хорооны даргын 2018 оны 08 дугаар сарын
13-ны өдрийн 11 дугаар тушаалын хавсралт



Томилолт, онгоцны тийзийн зардлын төсөв

№	Зардлын нэр		Зардлын хэмжээ /төг/	Нийт зардал /төг/
1	Азийн тоглолтын хоол, байрны зардал		8 хоног x 102.5\$ =820\$x x2465₮	2.021.300
2.	Онгоцны билетийн үнэ /Эрээн – Бээжин – Жакарта – Бээжин - Эрээн/		1.480.000	1.480.000
3.	Галт тэрэгний билетийн үнэ /Улаанбаатар – Эрээн – Улаанбаатар/		200.000	200.000
3.	Зам хоног	Зочид буудал	4 x хоног x80\$=320\$x2465₮	788.800₮
4.		Хоол	4 x хоног x 40\$= 160\$ x2465₮	394.400₮
Дүн				4.884.500